



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зээл-3313 МОН: УРГАМАЛ МАЛЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭРЭГСЛИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/65/НА-СТА-ТХН

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:enkhbaatare@audit.gov.mn">enkhbaatare@audit.gov.mn</a> Ахлах аудитор/аудитор: С.Алтанхуяг Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:altankhuyag@audit.gov.mn">altankhuyag@audit.gov.mn</a> Гэрээгээр гүйцэтгэсэн: Грант Торнтон Аудит ХХК-ийн захирал О.Идшинринжин Утас: 70110799 Цахим хаяг: <a href="mailto:Info@mn.gt.com">Info@mn.gt.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал .....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	22
4.5.1 Завсрын аудитын талаар.....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	23
5.1 Албан шаардлага .....	23
5.2 Зөвлөмж .....	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	27

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
КАПЕК	Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ТУХ	Төслийн удирдах хороо
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ДӨНТШ	Дотоодын өрсөлдөөнт нээлттэй тендер шалгаруулалт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.03 № 06/933

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гаалийн хяналтын болон мал эмнэлгийн лаборатори, хилийн боомтын хяналт, шалгалт, хорио цээрийн байгууламжуудын нөхцөл сайжруулах төслийн хүрээнд гаалийн хяналтын болон мал эмнэлгийн лабораториудыг шинээр барих барилга угсралтын ажлууд бүрэн хэрэгжсэн байна.

Уг төслийн хүрээнд баригдсан лабораториудаас 9,786,414.3 мянган төгрөгийн өртөг бүхий дөрвөн лабораторийн барилга нь улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад орж, холбогдох журмын дагуу хөрөнгийг шилжүүлэн бүртгэл хийсэн болно.

Харин 2,615,166.6 мянган төгрөгийн өртөг бүхий Дархан-Уул аймгийн гаалийн хяналтын лабораторийн барилгын ажил нь 100 хувийн гүйцэтгэлтэйгээр дууссан боловч улсын комисст хүлээлгэн өгөх ажиллагаа тайлант хугацаанд эхлээгүй тул санхүүгийн тайланд дуусаагүй барилгын бүртгэлд хэвээр үлдсэн байна.

Мөн тайлант онд 2020–2021 онуудад лабораториудад нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийн бүртгэлийг хийж, 7,532,319.6 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг “Бусад эргэлтийн бус хөрөнгө” ангиллаас хасаж, санхүүгийн тайланд өөрчлөлтийг тусгасан болно.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт дахь мал, амьтны хорио цээрийн байгууламж барих ажлын гүйцэтгэл 5 хувьд хүрээд зогсонги байдалд орсон тул 2024 оны 12 дугаар сард гэрээг цуцалсан. Тайлант онд ажлын тоо хэмжээ, төсвийг шинэчлэн шинэ гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарласан боловч нэг ч оролцогч санал ирүүлээгүй тул хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс хассан байна.

Дархан-Уул аймгийн гаалийн хяналтын лабораторийг хүлээлгэн өгөх Улсын комиссын дүгнэлт, ашиглалтад оруулах тухай тогтоол шийдвэр гарсны дараа дээрх барилга байгууламжийн хуримтлагдсан зардлыг дуусаагүй барилгын данснаас хасаж, хөрөнгө шилжүүлэх нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийх шаардлагатай.

### **Бусад асуудал**

АХБ-д хүргүүлсэн төслийн 2025 оны үйл ажиллагааны тайланд төслийн хэрэгжилтийг 94.8 хувьтай байна гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Итгэрэгээр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b><u>302,269,545.68</u></b>	<b><u>740,623,367.60</u></b>
<b>31</b>	<b>Мөнгөн хөрөнгө</b>	300,325,182.06	737,997,646.89
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>300,325,182.06</b>	<b>737,997,646.89</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>4,817,394.78</b>	<b>10,525,950.60</b>
31211	Төрийн сангийн харилцах	4,817,394.78	10,525,950.60
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	<b>295,507,787.28</b>	<b>727,471,696.29</b>
31221	Төрийн сангийн харилцах	295,507,787.28	727,471,696.29
<b>33</b>	<b>Авлага</b>	<b>1,864,363.62</b>	<b>267,999.99</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,864,363.62	267,999.99
<b>34</b>	<b>Урьдчилгаа</b>	<b>80,000.00</b>	<b>2,357,720.72</b>
34600	Урьдчилж гарсан зардал	80,000.00	2,357,720.72
<b>2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b><u>19,061,536,004.05</u></b>	<b><u>2,644,246,418.66</u></b>
<b>39</b>	<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>48,284,870.42</b>	<b>29,079,803.25</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>47,134,870.42</b>	<b>28,389,803.25</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	131,000,000.00	131,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(96,066,666.67)	(109,166,666.67)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,361,926.15	39,361,926.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,180,387.50)	(35,421,827.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,036,272.73	14,036,272.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,016,274.29)	(11,419,901.55)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,150,000.00</b>	<b>690,000.00</b>
39301	Программ хангамж	4,600,000.00	4,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,450,000.00)	(3,910,000.00)
<b>394</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>19,013,251,133.63</b>	<b>2,615,166,615.41</b>
39401	Эргэлтийн бус хөрөнгө	19,013,251,133.63	2,615,166,615.41
<b>3</b>	<b>Нийт хөрөнгийн дүн (3=2+1)</b>	<b><u>19,363,805,549.73</u></b>	<b><u>3,384,869,786.26</u></b>
<b>4</b>	<b>Нийт өр төлбөр</b>	<b><u>13,829,616.39</u></b>	<b><u>879,732,388.52</u></b>
<b>41</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	13,829,616.39	879,732,388.52
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>13,829,616.39</b>	<b>879,732,388.52</b>
41363	ХХОАТ-ын өглөг	5,270,050.00	1,409,332.78
41364	НДШ-ийн өглөг	8,559,566.39	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>878,323,055.74</b>
413610	Байгууллагад төлөх өглөг	-	878,323,055.74
<b>5</b>	<b>Цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>19,349,975,933.34</u></b>	<b><u>2,505,137,397.74</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	19,349,975,933.34	2,505,137,397.74
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>19,349,975,933.34</b>	<b>2,505,137,397.74</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	17,042,737,456.58	18,440,526,710.01
51220	Тайлант үеийн үр дүн	2,307,238,476.74	(15,935,389,312.27)
<b>6</b>	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн (6=4+5)</b>	<b><u>19,363,805,549.73</u></b>	<b><u>3,384,869,786.26</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*Итгэргөөр!*

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>3,203,383,660.20</b>	<b>5,299,393,296.88</b>
<b>11</b>	<b>Татварын орлого</b>	<b>99,620,759.64</b>	-
<b>114</b>	<b>Нэмэгдсэн өртгийн албан татвар</b>	<b>99,620,759.64</b>	-
120045	Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт - МУЗГ санхүүжилт	99,620,759.64	-
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>3,103,762,900.56</b>	<b>5,299,393,296.88</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>300,000.00</b>	<b>3,300,000.00</b>
120009	Тендерийн орлого	300,000.00	3,300,000.00
<b>122</b>	<b>Мөнгөн орлого</b>	<b>3,103,462,900.56</b>	<b>5,296,093,296.88</b>
120044	Зээлийн санхүүжилт /гадаад/	3,103,462,900.56	5,296,093,296.88
<b>2</b>	<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>899,510,701.09</b>	<b>457,238,750.35</b>
<b>21</b>	<b>Урсгал зардал</b>	<b>899,510,701.09</b>	<b>457,238,750.35</b>
<b>210</b>	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>899,510,701.09</b>	<b>457,238,750.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>200,273,774.86</b>	<b>282,867,600.00</b>
210101	Үндсэн цалин	200,273,774.86	282,867,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>21,532,673.20</b>	<b>30,971,535.00</b>
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	21,532,673.20	30,971,535.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,287,226.58</b>	<b>45,471,833.00</b>
210304	Байрны түрээс	40,287,226.58	45,471,833.00
<b>2104</b>	<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>12,700,853.53</b>	<b>6,737,375.78</b>
210401	Бичиг хэргийн материал	1,104,827.34	2,702,900.00
210402	Тээвэр, шатахууны зардал	7,717,959.10	2,182,279.28
210402	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,384,502.28	1,852,196.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	1,493,564.81	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,034,391.37</b>	-
210601	Багаж техник хэрэгсэл	2,509,185.51	-
210604	Урсгал засвар	1,525,205.86	-
<b>2107</b>	<b>Томилолтын зардал</b>	<b>10,568,211.11</b>	<b>10,720,000.00</b>
210702	Дотоод томилолт	10,568,211.11	10,720,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>588,199,990.42</b>	<b>56,655,545.40</b>
210801	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	557,042,671.02	29,075,436.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	27,360,000.00	24,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,048.00	-
210803	Даатгал	117,612.00	598,644.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,381,140.90	324,090.90
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	84,518.50	178,385.50
210806	Мэдээлэл сурталчилгааны зардал	-	2,478,989.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,913,580.02</b>	<b>23,814,861.17</b>

Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,206,773.44	4,609,794.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	15,706,806.58	19,205,067.17
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны ур дүн (3)=(1)-(2)</b>	<b>2,303,872,959.11</b>	<b>4,842,154,546.53</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>	<b>3,365,517.63</b>	<b>9,316,444.53</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	3,365,517.63	9,316,444.53
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>	-	<b>20,786,860,303.33</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз (бодит)	-	1,776,646.64
225012	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	20,785,083,656.69
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн (4)=(145-225)</b>	<b>3,365,517.63</b>	<b>(20,777,543,858.80)</b>
<b>5</b>	<b>Нийт үр дүн (5)=(3)+(4)</b>	<b>2,307,238,476.74</b>	<b>(15,935,389,312.27)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>573,857,281.57</b>	<b>1,058,773,621.96</b>
<b>11</b>	<b>Татварын орлого</b>	<b>564,879,428.56</b>	<b>1,044,933,177.43</b>
1200044	Байгууллагын ажил, үйлчилгээний орлого	564,879,428.56	1,044,933,177.43
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>8,977,853.01</b>	<b>13,840,444.53</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,977,853.01</b>	<b>13,840,444.53</b>
120001	Тендерийн орлого	300,000.00	3,300,000.00
120010	Бусад орлого	5,312,334.40	1,224,000.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,365,518.61	9,316,444.53
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>421,274,273.70</b>	<b>445,727,240.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>226,943,644.99</b>	<b>321,069,971.37</b>
210101	Үндсэн цалин	226,943,644.99	321,069,971.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой зардал</b>	<b>36,843,170.00</b>	<b>45,471,833.00</b>
210301	Байрны түрээс	36,843,170.00	45,471,833.00
<b>2104</b>	<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>11,158,144.80</b>	<b>6,160,096.50</b>
210401	Бичиг хэргийн материал	900,000.00	902,900.00
210402	Тээвэр шатахууны зардал	6,847,036.36	3,420,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн зардал	2,061,042.72	1,837,196.50
210404	БҮТЭЗ	1,350,065.72	-
<b>2105</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,438,000.00</b>	<b>-</b>
240501	Багаж, техник хэрэгсэл	10,182,455.00	-
210604	Урсгал засвар	1,255,545.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,327,600.00</b>	<b>10,720,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	9,327,600.00	10,720,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>119,647,768.10</b>	<b>57,695,545.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	92,076,231.60	30,115,436.00
210802	Аудитын үйлчилгээ	24,000,000.00	24,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	598,644.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40,000.00	324,090.90
210806	Мэдээлэл сурталчилгааны зардал	3,166,050.00	2,478,989.00
210807	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	84,518.50	178,385.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,915,945.81</b>	<b>4,609,794.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,915,945.81	4,609,794.00
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2)</b>	<b>152,583,007.87</b>	<b>613,046,381.69</b>
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн (5)</b>	<b>171,284,374.00</b>	<b>173,597,270.22</b>
<b>22</b>	<b>Хөрөнгийн бусад зардал</b>	<b>171,284,374.00</b>	<b>173,597,270.22</b>
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (6)=(4)-(5)</b>	<b>(171,284,374.00)</b>	<b>(173,597,270.22)</b>
<b>14</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>		
1450001	Ханшийн зөрүүгийн гарз/бодит бус/	-	1,776,646.64

Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(1,776,646.64)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (8)=(3)+(6)+(7)	(18,701,366.13)	437,672,464.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	319,026,548.19	300,325,182.06
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,325,182.06	737,997,646.89

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл</b>	-	<b>17,047,866,259.23</b>	<b>17,047,866,259.23</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(5,128,802.63)	(5,128,802.63)
3	Тайлант үеийн үр дүн	-	2,307,238,476.74	2,307,238,476.74
4	<b>2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэл</b>	-	<b>19,349,975,933.34</b>	<b>19,349,975,933.34</b>
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(909,449,223.31)	(909,449,223.31)
6	Тайлант үеийн үр дүн	-	(15,935,389,312.27)	(15,935,389,312.27)
7	<b>2025 оны 12 сарын 31-ны үлдэгдэл</b>	-	<b>2,505,137,397.76</b>	<b>2,505,137,397.76</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,891,690,000.00</b>	<b>4,866,650,835.94</b>	<b>25,039,164.06</b>	<b>99.5%</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>911,490,000.00</b>	<b>905,093,446.27</b>	<b>6,396,553.73</b>	<b>99.3%</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>911,490,000.00</b>	<b>905,093,446.27</b>	<b>6,396,553.73</b>	<b>99.3%</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>284,305,000.00</b>	<b>284,304,896.37</b>	<b>103.63</b>	<b>100.0%</b>
210101	Үндсэн цалин	284,305,000.00	284,304,896.37	103.63	100.0%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>36,844,000.00</b>	<b>35,541,075.00</b>	<b>1,302,925.00</b>	<b>96.5%</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,222,000.00	24,097,550.00	1,124,450.00	95.5%
210202	Тэтгэмжийн даатгал	3,006,000.00	3,005,760.00	240.00	100.0%
210203	ҮОМШ-ний даатгал	1,422,500.00	1,321,070.00	101,430.00	92.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,503,500.00	1,502,880.00	620.00	99.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,690,000.00	5,613,815.00	76,185.00	98.6%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой зардал</b>	<b>45,800,000.00</b>	<b>45,471,833.00</b>	<b>328,167.00</b>	<b>99.3%</b>
210304	Байрны түрээс	45,800,000.00	45,471,833.00	328,167.00	99.3%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	<b>6,883,000.00</b>	<b>6,160,096.50</b>	<b>722,903.50</b>	<b>89.5%</b>
210401	Бичиг хэрэг	903,000.00	902,900.00	100.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	3,450,000.00	3,420,000.00	30,000.00	99.1%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,840,000.00	1,837,196.50	2,803.50	99.8%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс	690,000.00	-	690,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>-</b>	<b>1,000,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	-	1,000,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,720,000.00</b>	<b>10,720,000.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
210702	Дотоод албан томилолт	10,720,000.00	10,720,000.00	-	100.0%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>523,938,000.00</b>	<b>520,895,545.40</b>	<b>3,042,454.60</b>	<b>99.4%</b>
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	496,401,000.00	493,315,436.00	3,085,564.00	99.4%
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,000,000.00	24,000,000.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	107,000.00	-	107,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	598,644.00	1,356.00	99.8%

Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	350,000.00	324,090.90	25,909.10	92.6%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,480,000.00	2,478,989.00	1,011.00	99.9%
210807	Банкны үйлчилгээний шимтгэл	178,385.50	178,385.50	-	100.0%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0%
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,980,200,000.00</b>	<b>3,961,557,389.67</b>	<b>18,642,610.33</b>	<b>99.5%</b>
220001	Барилга байгууламж	1,812,200,000.00	1,793,813,389.67	18,386,610.33	99.0%
222001	Тоног төхөөрөмж	2,168,000,000.00	2,167,744,000.00	256,000.00	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,296,093,296.88</b>	<b>-</b>	<b>5,296,093,296.88</b>	
122	<b>Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих</b>	<b>5,296,093,296.88</b>	<b>-</b>	<b>5,296,093,296.88</b>	
120044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,296,093,296.88	-	5,296,093,296.88	
<b>4</b>	<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>300,325,182.06</b>		
<b>5</b>	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>737,997,646.89</b>		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>5</b>	<b>5</b>		<b>100.0%</b>
620001	Удирдах ажилтан	1	1		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсөл, түүний үйл ажиллагаа

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийг санхүүжүүлэх 3313-МОН тоот зээлийн гэрээ 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүчин төгөлдөр болсноор төсөл хэрэгжүүлэх хугацаа тоологдож эхэлсэн ба төслийн явцад нийтдээ 4 удаагийн сунгалтыг хийж Сангийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 01/8783 тоот албан бичгээрх хүсэлтийн дагуу АХБ-ны 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн албан захидлаар зээлийн гэрээний хугацааг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал сунгасан байна.

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн зорилго нь Дэлхийн худалдааны байгууллагын “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах хэлэлцээр”-т нийцүүлэн Монгол Улсын ургамал, малын эрүүл ахуйн хяналтын тогтолцоог сайжруулах, хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүний олон улсын худалдааг дэмжих замаар эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах юм. Тус зорилгодоо хүрэхэд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- Лабораториудын үйл ажиллагааг тогтвортой явуулах үүднээс тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, барилга байгууламжуудыг сайжруулах, ажилтан, ажиллагсдыг сургах;
- SPS (Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал)-ийн хяналт шалгалтыг мэдээллийн технологи болон эрсдэлийн менежментэд суурилан гүйцэтгэх;
- SPS-ийн тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх хэрэгцээг хангахад хувь нэмэр оруулах.

Төслийг амжилттай хэрэгжүүлснээр Монгол Улсын SPS-ийн хяналт, шалгалтын тогтолцоо олон улсын стандартад нийцэж, лабораторийн шинжилгээний чадавх сайжирна. Үүний үр дүнд КАРЕК (Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа)-ийн гишүүн орнуудын сайд нарын баталсан SPS-ийн нэгдмэл төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад бодитой хувь нэмэр оруулж, улмаар эдийн засгийг төрөлжүүлэх замаар тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих, мөн КАРЕК-ийн тээврийн коридорын дагуу хийгдэж буй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой юм.

Төслийн зээлийн хугацааг төсөл хэрэгжүүлэх нэгжийг төлөвлөсөн хугацаанд амжиж байгуулаагүй, КОВИД-19 цар тахалтай холбоотой хөл хорио, хязгаарлалтаас үүдэн барилгын бараа материалын хомсдол үүсэж үнийн өсөлт бий болсон, олон улсын ачаа тээвэр саатсан, төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг татан буулгаснаас үүдэн хяналтын удирдлагын системийн бүрэлдэхүүн хэсгийг дахин үнэлж өөрчлөх шаардлагатай болсон зэргээс үүдэн лабораториудын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх зарим гэрээг хэрэгжүүлэхэд хүндрэл учирсан гэх мэт олон учир шалтгааны улмаас тус зээлийн гэрээний хугацааг нийт 5 жил 4 сараар сунгасан байна.

Сунгалт хийгдсэн байдал:

**Сунгалт 1:** Зээлийн гэрээний хугацааг 2022 оны 6 дугаар сарын 30 хүртэл нийт 12 сараар (төсөл хэрэгжиж дуусгах хугацаа 2021 оны 12 дугаар сарын 30 байхаар тусгаж) сунгасныг АХБ-ны 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн албан захидлаар баталгаажуулсан.

**Сунгалт 2:** Зээлийн гэрээний хугацааг 2023 оны 11 дүгээр сарын 11 хүртэл нийт 16.5 сараар (төсөл хэрэгжиж дуусгах хугацаа 2023 оны 05 дугаар сарын 11 байхаар тусгаж) сунгасныг АХБ-ны 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн албан захидлаар баталгаажуулсан.

**Сунгалт 3:** Зээлийн гэрээний хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 11 хүртэл нийт 24 сараар (төсөл хэрэгжиж дуусгах хугацаа 2025 оны 05 дугаар сарын 11 байхаар тусгаж) сунгасныг АХБ-ны 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн албан захидлаар баталгаажуулсан.

**Сунгалт 4:** Зээлийн гэрээний хугацааг 2026 оны 11 дүгээр сарын 01 хүртэл нийт 11 сараар (төсөл хэрэгжиж дуусгах хугацаа 2026 оны 08 дугаар сарын 01 байхаар тусгаж) сунгасныг АХБ-ны 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн албан захидлаар баталгаажуулсан.

Төслийн үйл ажиллагаанаас мал, амьтны хорио цээрийн байгууламж барих ажил хасагдан төслийн санхүүжилтээс 3.5 сая орчим ам.доллар хэмнэгдэн үлдэж байгааг Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангахад импортоор орж ирж буй ургамал, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн шинжилгээг гол хилийн боомтууд дээр хийх боломжийг бүрдүүлснээр төслийн тогтвортой байдлыг хангах, үр дүнг бататгах ач холбогдолтой гэж үзсэн тул АХБ, Сангийн яам болон хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын шийдвэрээр төслийн хугацааг 2026 оны 11 дүгээр сарын 1-нийг хүртэл сунгаж, хилийн боомтуудад лабораторийн шинжилгээний тусгай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг нэмэлтээр гүйцэтгэхээр хүсэлтийг АХБ руу илгээсэн.

### 3.2 Төслийн гадаад, дотоод орчин

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар баталсан "Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц, орон тоог батлах тухай" журам,
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам".

Татварын чөлөөлөлтийн дүнг санхүүгийн тайлангийн "Тодруулга 14 Татварын чөлөөлөлт"-д тодруулна.

ТХН-д хэрэгжиж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах, арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах, арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд өмчийн өөрчлөлтийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд 909,449.2 мянган төгрөгийг тусгасан байна. Тус өөрчлөлт нь Засгийн газрын НӨАТ-ын чөлөөлөлтийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, зарлагаар бүртгэсэн бичилтийг буцаан залруулснаас үүссэн болно.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,978,935.7 мянган төгрөгөөр буюу 82 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	300,325.2	737,997.6	437,672.5
Авлага	1,864.4	268.0	(1,596.4)
Урьдчилгаа	80.0	2,357.7	2,277.7
Үндсэн хөрөнгө	48,284.9	29,079.8	(19,205.1)
Эргэлтийн бус хөрөнгө	19,013,251.1	2,615,166.6	16,398,084.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>19,363,805.5</b>	<b>3,384,869.8</b>	<b>15,978,935.7</b>
Өр төлбөр	13,829.6	879,732.4	865,902.8
Эздийн өмч	19,349,975.9	2,505,137.4	16,844,838.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>19,363,805.5</b>	<b>3,384,869.8</b>	<b>15,978,935.7</b>

Дараах дансуудад материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 737,997.6 мянган төгрөг болж 437,672.5 мянган төгрөгөөр өссөн нь нэгээс ес дүгээр сарын нийт зардлын дүн болох 118,661.93 /WA00042/ ам.долларыг 2025.12.01-ны өдөр хүлээн авснаас шалтгаалжээ.
- Дансны авлагын бууралт нь 2 ажилтнаас өмнөх оны 1,596.4 мянган төгрөгийн авлагыг суутган авснаар буурсан.
- Урьдчилж гарсан зардал дансны 2,277.7 мянган төгрөгийн өсөлт нь шатахууны карт цэнэглэлтийн үлдэгдэл болон Инфосистемс ХХК-ийн программ хангамжийн лицензийн төлбөр.

**Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

- Үндсэн хөрөнгөд тайлант хугацаанд нэмэгдсэн, хасагдсан хөдөлгөөн байхгүй ба элэгдлийн зардлын дүнгээр дансны үнэ буурсан.
- Эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтэй байсан гаалийн болон мал эмнэлгийн лабораторийг ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 792 дугаар тоот тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдэд 9,786,414.3 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг шилжүүлсэн бол түүнд ашиглагдах тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн актын дагуу шилжүүлж, данснаас хассан нь өмнөх оноос 16,398,084.0 мянган төгрөгөөр буурахад хүргэсэн.
- Өр төлбөрийн үлдэгдэл 879,732.4 мянган төгрөг болж 865,902.8 мянган төгрөгөөр өссөн нь Грийн Ресурс Констракшн ХХК-ийн барилгын ажлын гүйцэтгэлийн чанарын баталгааны барьцаа төлбөр, Дархан-Уул аймгийн гаалийн хяналтын лабораторийн барилгын ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл төлбөр, барилгын ажлын техник хяналтын төлбөр зэргээс шалтгаалсан байна.
- Эздийн өмчийн хөдөлгөөн нь балансаас баланст шилжүүлсэн хөрөнгөд хамаарах дүнгээр буурсан.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад эх үүсвэрээс 5,296,093.3 мянган төгрөг, нийт зарлагыг 4,891,690.0 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг зээлийн эх үүсвэрээр 4,891,690.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс мэргэжлийн үйлчилгээний төлбөрт 493,315.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 3,961,557.4 мянган төгрөг, төслийн нэгжийн зардалд 411,778.0 мянган төгрөгийг зарцуулж 99.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гүйцэтгэлээр гадаад эх үүсвэрээс 5,296,093.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны бус орлого 12,616.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,866,650.8 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 25,039.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь нөлөөлсөн болно.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80104	Гадаад зээлийн тусламжаар хэрэгжүүлэх ажил	3,980,200.0	3,961,557.4	18,642.6	99.5
70207	Үйл ажиллагааны урсгал зардал	911,490.0	905,093.4	6,396.6	99.3
	<b>Дүн</b>	<b>4,891,690.0</b>	<b>4,866,650.8</b>	<b>25,039.2</b>	<b>99.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

ТХН болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан зээлийн гэрээнд туссанаар 15,000.0 мянган ам.доллар буюу 43,891,588.8 мянган төгрөгийн төслийг хэрэгжүүлж, нийт 7 хөтөлбөрийн 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант хугацаанд төслийн хүрээнд хийгдсэн гэрээний нийт дүн 10,264.0 сая ам.доллар буюу цэвэр зээлийн санхүүжилтийн 69.7 хувьтай байгаа бол нийт ашиглалт 10,223.0 мянган ам.доллар буюу 69.4 хувьтай байна. Үүнд төслийн хүрээнд байгуулсан боловч цуцалсан гэрээ зэргийг хасаж, санхүүжилтийн дахин хуваарилалт хийсний дараах байдлаар тооцон доорх хүснэгтэд санхүүжилтийн ангилал тус бүрээр гэрээлсэн дүн болон ашиглалтыг тус тус харуулсан болно.

Зээлийн ашиглалтыг төслийн бүрэлдэхүүн тус бүрээр авч үзэхэд:

#### Бүрэлдэхүүн - 1

Гаалийн хяналтын болон мал эмнэлгийн лаборатори, хилийн боомтын хяналт, шалгалт, хорио цээрийн байгууламжуудын нөхцөл сайжруулах үйл ажиллагаанд нийт 7,308,437.94 ам.доллар буюу нийт зээлийн 49.6 хувьтай тэнцэх дүнгээр гэрээ байгуулж, нийт 6,857,039.55 ам.долларын санхүүжилт хийгдсэн нь нийт гэрээлсэн дүнгийн 75.6 хувьтай тэнцэж байна.

#### Бүрэлдэхүүн - 2

SPS-ийн Хяналтын удирдлагын систем (ХУС) ашиглалтад оруулах үйл ажиллагаанд нийт 1,070,303.92 ам.доллар буюу нийт зээлийн 7.3 хувьтай тэнцэх үнийн дүн бүхий гэрээ байгуулж, нийт 1,026,053.64 ам.долларын санхүүжилт хийгдсэн нь нийт гэрээлсэн дүнгийн 96.0 хувьтай тэнцэж байна.

#### Бүрэлдэхүүн - 3

SPS-ийн хяналт, шалгалт хийх аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэх үйл ажиллагаанд нийт 497,128.33 ам.доллартай тэнцэх дүнгээр буюу нийт зээлийн 3.37%-тай тэнцэх үнийн дүнтэй гэрээ байгуулж, мөн хэмжээний санхүүжилт хийгдсэн нь нийт гэрээлсэн дүнгийн 100 хувьтай тэнцэж байна.

#### Бүрэлдэхүүн - 4

Төслийн удирдлагын үйл ажиллагаанд нийт 1,219,213.31 ам.доллар буюу нийт зээлийн ашиглалтын 8.26 хувьтай тэнцэх санхүүжилтийг зарцуулсан байна. Үлдсэн санхүүжилт нь хүү, шимтгэл, сургалт болон урьдчилгааны дансны зарцуулалт байна.

Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/ам доллараар/

Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
<p>Бүрэлдэхүүн 1.</p> <p>1а. Мэргэжлийн хяналтын болон мал эмнэлгийн лабораторийн 5 шинэ байгууламжийг барьж хүлээлгэн өгнө.</p> <p>1б. Лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодис болон хяналтын байцаагчийн тоног төхөөрөмж нийлүүлэх.</p>	2025 оны 12 сар	(i) Дорноговь, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотын лабораториудын нөхцөлийг сайжруулах (ii) Алтанбулаг, Замын-Үүд хилийн боомтууд дахь лаборатори, хорио цээрийн байгууламжуудыг шинэчлэхэд ЗГ-т туслалцаа үзүүлэх болон дэд бүтэц, тоног төхөөрөмж, чанарын менежмент, сургалт, итгэмжлэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгод чиглэнэ.	90.5%*	7,308,437.94	6,857,039.55
<p>Бүрэлдэхүүн 2.</p> <p>SPS-ийн Хяналтын удирдлагын систем (ХУС) ашиглалтад орно.</p>	2025 оны 12 сар	Хяналтын удирдлагын систем бий болсноор хөдөө аж ахуйн гаралтай импорт, экспортын бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох, зөвшөөрөл авах өргөдөл/хүсэлт гаргахад шаардаж буй баримт бичгийг давхардуулан бүрдүүлэхээс сэргийлнэ. ХУС нь эрсдэлд суурилсан импортын хяналтын системийг иж бүрэн хөгжүүлэх замаар эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг удирдан зохион байгуулах ажиллагааг бүрэн автоматжуулна.	100%	1,070,303.92	1,026,053.64
<p>Бүрэлдэхүүн 3.</p> <p>SPS-ийн хяналт шалгалт хийх аргачлалыг олон улсын стандартад нийцүүлнэ.</p>	2022 оны 3 сар	Дээж авах, шинжилгээ хийх аргачлалыг ДХБ-аар хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартад нийцүүлснээр хяналт шалгалтад зарцуулж буй хугацааг багасгаж олон улсад хүлээн зөвшөөрөгдөн, ДХБ-ын гишүүн орнуудтай худалдаа хийх боломжийг бүрдүүлнэ.	100%	497,128.33	497,128.33

**Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Бүрэлдэхүүн 4. төслийн удирдлагын үйл ажиллагаанд	2025 оны 11 сар	Төслийн удирдах хорооны сүүлийн хурал 2025 оны 9-р сарын 25-ны өдөр болсон ба тус хурлаар төслийн 2025 оны үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлт, төслийн зээлийн хугацаа сунгах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.	99%	1,219,213.31	1,219,213.31
<b>Төслийн нийт хэрэгжилт</b>			<b>97%</b>	<b>10,095,083.50</b>	<b>9,599,434.83</b>

\*Лабораторийн барилга, байгууламжийг хүлээлгэн өгөх ажлын БА1-багц нэг гэрээг хэсэгчлэн цуцалж, Дархан-Уул аймгийн гаалийн хяналтын лабораторийн байгууламжийн барилга угсралтын ажлыг цааш үргэлжлүүлэх шинэ гүйцэтгэгчээр Метадакс инженеринг ХХК болон Өгөөмөрөн шанд ХХК-ийн түншлэл шалгарч 2025 оны 5 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулсан. Хуулийн дагуу захиалагч барилга угсралтын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг 6 дугаар сарын 24-ний өдөр авснаар талбай дээрх ажил эхэлсэн байна.

Тайлант хугацаанд Дархан-Уул аймгийн гаалийн хяналтын лабораторийн байгууламжийн барилга угсралтын ажил бүрэн дуусаж, ТХН-ээс улсын комисс ажиллуулах хүсэлтийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн. Барилгыг байнгын ашиглалтад өгөхөд бэлтгэн туршилт тохируулгын ажлууд хийгдэж байна. Барилга угсралтын ажлын нийт явц 100 хувь ба гүйцэтгэгчийн гэрээний гүйцэтгэл 95 хувийн хэрэгжилттэй байгаа ба гүйцэтгэгчид эхний хоёр гүйцэтгэлийн төлбөрт нийт 383,649.0 ам.долларын төлбөрийг 9 болон 12 дугаар сард шилжүүлсэн.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант хугацааны төслийн худалдан авалтын төлөвлөгөөний дагуу ТХН нь дараах томоохон худалдан авах ажиллагааг холбогдох дүрэм, журамд нийцүүлэн үе шаттайгаар зохион байгуулсан. Худалдан авалтын үйл ажиллагааг АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын дагуу болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдсөн.

- Дархан-Уул аймаг дахь гаалийн хяналтын лабораторийн барилгын ажил

2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр тендерийн үнэлгээний хороог байгуулснаар тендерийг 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зарлаж 2 дугаар сарын 24-ний өдөр нээсэн. Тендерт нийт гурван оролцогч материалаа хугацаанд нь бүрдүүлэн ирүүлсэн бөгөөд үнэлгээний хороо материал бүрд нарийвчилсан үнэлгээ хийсэн. Тендерийн баримт бичигт тусгагдсан “Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа”-ны 35.5 дугаар зүйлийн дагуу оролцогчдын үнийн санал, шаардлага хангалтыг харьцуулж үзээд хамгийн бага харьцуулсан үнэтэй тендер ирүүлсэн компанийг шалгаруулсан байна.

- Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн өргөтгөлийн тоног төхөөрөмж

2025 оны 1 дүгээр сарын 17-нд орон нутгийн Өдрийн сонинд тендерийн урилгыг нийтэлж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас болон Сангийн яамны цахим хуудсанд зэрэгцүүлэн байршуулсан байна. Тендерийн баримт бичгийг нийт дөрвөн компани худалдан авсан бөгөөд материалаа бүрдүүлэн ирүүлэх эцсийн хугацааг сунгалгүй,

**Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр тендерийг нээсэн. Баримт бичгийн бүрдүүлэлт, техникийн шаардлагын нийцэл зэргийг үнэлэхэд “Саммит Компьютер Технологи” ХХК болон “Ай Ти Зон” ХХК нь шаардлага хангасан оролцогчоор үлдсэн байна.

Үнэлгээний үйл явц нь тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 37.2 дугаар зүйлийн дагуу хийгдэж, оролцогч бүрийн харьцуулах үнийг тогтоон, хамгийн бага харьцуулсан үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн гэж үзсэн байна. Ингэснээр “Саммит Компьютер Технологи” ХХК тендерт шалгарч, 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр тус компанитай гэрээ байгуулжээ.

№	Багцын дугаар	Нэр	Төсөвт өртөг	ХАА-ны арга	Зарласан огноо	Хүлээн авсан хугацаа	Биелэлт
<b>100,000-аас 1 сая хүртэл ам.долларын төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ – Бараа, ажил</b>							
1	CW1-2 /BA1-2	Дархан-Уул аймаг дахь Гаалийн хяналтын лаборатори	902,758.00	ДӨНТШ	2025-01-14	2025-02-24	Шалгарсан гүйцэтгэгчтэй 5-р сарын 6-ны өдөр гэрээ байгуулсан.
2	G3	Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн өргөтгөлийн тоног төхөөрөмж	863,320.00	ДӨНТШ	2025-01-17	2025-02-14	Шалгарсан гүйцэтгэгчтэй 3-р сарын 28-ны өдөр гэрээ байгуулсан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг дэмжих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд ТХН-ийн үйл ажиллагааг сайжруулах, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитор Б.Энхцэцэг, туслах аудитор Г.Гүндалай, Б.Адъяацэрэн нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер С.Уянга, чанарын хяналтын партнер Б.Дэлгэрмаа нар, гэрээт ажлын партнер О.Идшинринжин, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Алтанхуяг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 02/06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,674,360.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,743.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ТХН нь дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-т заасан шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр тээврийн цагдаагийн газарт 20-29 УБҮ улсын дугаартай төслийн нэгжийн нэр дээрх Тоёота Ланд Круйзер 200 загварын автомашины улсын дугаарыг цэнхэр өнгийн дэвсгэртэй болгох хүсэлт илгээсэн байна.
- Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа, бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй байх, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх зэрэг арга хэмжээг авч ажилласан.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дээрх хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл нь Шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 68 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй болно.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д өөрчлөлт орж, 2025 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн А/41 дугаар тушаалаар тухайн журмын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дараах эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

“Монгол Улсын Засгийн газраас олон улсын гэрээний хүрээнд гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд үзүүлсэн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн дүнг хөрөнгийн өртөгт оруулахгүй.”

Энэ заалтын дагуу төсөл хэрэгжүүлэгч нэгж нь өмнөх тайлант хугацаанд татварын чөлөөлөлтийн дүнг орлогоор бүртгэж, мөн хөрөнгийн өртөгт хуримтлуулан бүртгэсэн бол тухайн бичилтийг буцааж залруулах шаардлагатай. Иймд тайлант хугацаанд чөлөөлөгдсөн НӨАТ-ын дүнг хөрөнгийн өртөг болон зардлаар бүртгэсэн эсэхийг нягтлан шалгахыг анхааруулж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,613,277.5 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад аудитын явцад залруулсан.

### **Залруулсан алдаа:**

Аудитаар нягтлан бодох бүртгэл (НББ)-ийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журмын 2025 оны шинэчлэлт хийгдэхээс өмнө Засгийн газрын НӨАТ-ын чөлөөлөлтийн дүнгээр үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон холбогдох зарлагыг бүртгэж орлогын тайланд тусгасныг залруулсан.

Аудитаар нийт 1,874.1 мянган төгрөгийн 8 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1,606.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 268.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,874.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,869.5 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

### **5.1 Албан шаардлага**

5.1.1. Барилга байгууламжийг өмчийн бүртгэлд авах үйл явц удааширсан нь хөрөнгийн эзэн, хариуцагч байгууллага албан ёсоор баталгаажаагүй, ашиглалтын болон хамгаалалтын журам бүрэн мөрдөгдөх боломжгүй, санхүүгийн бүртгэлд хөрөнгийг тодорхой хугацаанд тусгаагүй зэрэг алдаа зөрчил гарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ.”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 9 дүгээр бүлгийн 9.3-д “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.” 9.4-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалтаар хангах бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ” гэсэн заалтуудын хэрэгжилтийг тус тус хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Барилга байгууламжийг өмчийн бүртгэлд бүртгүүлэх үйл явц удааширах үүнтэй холбоотой үүсэж буй ашиглалтын болон хамгаалалтын журам мөрдөгдөхгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлагыг төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлэх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.2. Мэргэжлийн хяналтын газар татан буугдсанаар хүлээж авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг аймаг, сумын Гаалийн газарт хүлээлцэхдээ анхны нийлүүлэгчээс хүлээн авсан хөрөнгийн жагсаалтын дагуу хүлээлцэж, баталгаажуулаагүй байна. Лабораторийн барилга ашиглалтад ороогүй байхад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын хадгалалтын горим бүрэн хангагдаагүй зориулалтын бус газруудад, тодорхой хариуцах эзэнгүй, байнгын хяналтгүй 4-5 жил хадгалагдсан тул зарим хөрөнгийн бүрэн бүтэн байдал эрсдэлд өртөх, шамшигдан алга болох, мэдрэмтгий чанартай урвалж бодисын ашиглах хугацаа дууссан зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Сангийн сайдын 2021 оны Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 9.2.32-т “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг баримтлан эцсийн өмчлөгчид шилжүүлнэ” гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Лабораторийн барилга ашиглалтад ороогүй байхад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг эзэмшигч, ашиглагч байгууллагад бүрэн шилжүүлж өгөөгүй, зориулалтын бус газруудад хариуцсан эзэнгүй хадгалагдаж буй зөрчлийг арилгах албан шаардлагыг Гаалийн ерөнхий газар болон төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлэх.

5.1.3. Төсөлд ашиглагдах суудлын автомашины замын зарцуулалтаас 11,982 км (87 хувь) нь орон нутагт явснаас үүний 1,531 км нь Говьсүмбэр, Өмнөговь гэх зэрэг төсөлд хамааралгүй аймгууд руу явсан, үлдсэн 1,829 км (13 хувь) нь хот дотор ашигласан байна.

Энэ нь “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн 6.1-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно”, “Сангийн сайдын 2021 оны Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 7.3 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах, төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих үүрэгтэй” гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төслийн санхүүгийн тайланд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг хот дотор ашиглаж байгаа, төсөлд хамааралгүй үйл ажиллагаанд ашигладаг, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.2.1 Илрүүлэлт:** Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор байгуулагдсан лабораториудад ашиглагдаж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн ашиглахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, зааврыг нийлүүлэгч байгууллага болон төслийн нэгжээс хангалттай түвшинд зохион байгуулаагүй байна. Мөн тоног төхөөрөмжийн ашиглалт, шинжилгээний арга зүйтэй холбоотой сургалт, дадлага хангалтгүй зохион байгуулагдсаны улмаас лабораторийн үйл ажиллагаа зорилгын дагуу бүрэн хэрэгжихгүй, удаашралтай хэвээр байна.

Энэхүү нөхцөл байдал нь лабораторийн тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглах боломжийг хязгаарлаж, улмаар шинжилгээний үйлчилгээний чанар, хүртээмж буурахад нөлөөлж байна. Үүний үр дүнд лабораторийн үйл ажиллагааны үр ашиг хангалтгүй байгаа бөгөөд өнөөг хүртэл тоног төхөөрөмжийг ашиглах сургалт, чадавхжуулах бодит хэрэгцээ өндөр хэвээр байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 10 дугаар зүйлийн 10.3. “Төсөл хэрэгжүүлэх нэгж зээлийн гэрээний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, байнгын дотоод хяналт тавьж Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тайлагнана”, 10.4. “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага өөрийн хариуцах гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ болон хэрэгжиж дууссаны дараа эцсийн үнэлгээ хийн харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Лабораторийн ашиглалтад байгаа тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг зохион байгуулах, 5 лабораторийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж сургалтын нэгдсэн төлөвлөгөө гарган, холбогдох санхүүжилтийг төлөвлөн хэрэгжүүлэх.

**5.2.2 Илрүүлэлт:** Төсөл нь үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг татварын зорилгоор тогтоосон элэгдлийн хугацаатай ижил байдлаар тогтоон элэгдүүлж байна.

Энэ нь УСНББОУС 17, 66-р параграф: ашиглалтын хугацаа бодит ашиглах хугацаанд үндэслэнэ гэсэн шаардлага, “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” 10.24. “Хөрөнгийн ашиглалтын хугацаа нь байгууллага тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацаа, эсхүл тухайн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэхээр хүлээгдэж буй бүтээгдэхүүний хэмжээ, түүнтэй адилтгах нэгж юм” ,10.26 “Ашиглалтын хугацааг жил бүр хянаж, тооцооллын өөрчлөлт хийх” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн бодит ашиглалтын нөхцөл, үйл ажиллагаанд ашиглагдах хугацаа болон эдийн засгийн үр өгөөж өгөх бодит хугацаанд үндэслэн дахин үнэлж тогтоох, уг хугацааг санхүүгийн бүртгэл болон элэгдлийн бодлогод тусган ажиллах.

5.2.3 Илрүүлэлт: Түрээс, ашиглалт, томилолт, шатахуун зэрэг 122 ширхэг 125,933.1 мянган төгрөгийн зардлын гүйлгээг аккруэл сууриар өглөгийн тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд мөнгөн хөрөнгөтэй харьцуулан бүртгэсэн байна.

Тайлант хугацаанд 45,471.8 мянган төгрөгийн түрээсийн зардал, 10,720.0 мянган төгрөгийн томилолтын зардал, 40,001.6 мянган төгрөгийн мэргэжлийн үйлчилгээний зардал, 29,739.7 мянган төгрөгийн бусад зардал, нийт 125,933.1 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэн тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө.", 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлөх

5.2.4 Илрүүлэлт: Төслийн өмнөх санхүүгийн мэргэжилтэн Нийгмийн даатгалын тайлан хугацаа хоцроосон торгууль 250.0 мянган төгрөгийн авлага, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтөөс үүссэн зөрүү болох 18.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ба тухайн ажилтнууд нь 2023, 2025 онд ажлаас чөлөөлөгдсөн боловч авлагыг төлж барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Учирсан өр төлбөрийг хариуцсан ажилтан болон/эсхүл холбогдох төсөл хэрэгжүүлэгч удирдлагын түвшинд хууль, тогтоомжийн дагуу нөхөн төлүүлж, бүрэн барагдуулан, төслийг санхүүгийн аливаа хохиролгүй болгох арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу илэрхийлсэн тусган		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Засгийн газрын НӨАТ-ын чөлөөлөлтийн дүнгээр үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон холбогдох зарлагыг бүртгэсэн.	1	1,613,277.5	-	-	1	1,613,277.5	1	1,613,277.5	-	-	-	-
	<b>Дүн</b>		<b>1,613,277.5</b>				<b>1,613,277.5</b>		<b>1,613,277.5</b>				

Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал		
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо			
1	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудаас 268.0 мянган төгрөгийн авлагыг суутган авч бүртгээгүй.	1	268.0	-	-			1	268.0	-	-	-	-	-
2	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж өгөх бодит хугацаанд үндэслэж тогтоогоогүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
3	Барилга байгууламжийг өмчийн бүртгэлд авах үйл явц удааширсан нь хөрөнгийн эзэн, хариуцагч байгууллага албан ёсоор баталгаажаагүй, ашиглалтын болон хамгаалалтын журам бүрэн мөрдөгдөх боломжгүй, санхүүгийн бүртгэлд хөрөнгийг тодорхой хугацаанд тусгаагүй зэрэг алдаа зөрчил гарсан байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
4	2020-2021 онд буюу лабораторийн барилга ашиглалтад орохоос өмнө тоног төхөөрөмж, эд хогшлыг нийлүүлэн хүлээлгэн өгснөөс шалтгаалан уг хөрөнгө зориулалтын дагуу ашиглагдаагүй, хангалтгүй нөхцөлд удаан хугацаанд хадгалагдсан, зарим дагалдах урвалж бодисын хугацаа дууссан байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
5	Лабораториудад ашиглагдаж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн ашиглахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, зааврыг нийлүүлэгч	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-

**Зээл-3313 МОН: Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	байгууллага болон төслийн нэгжээс хангалттай түвшинд зохион байгуулаагүй байна.													
6	Түрээс, ашиглалт, томилолт, шатахуун зэрэг зардлын гүйлгээг аккрузал сууриар өглөгийн тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд мөнгөн хөрөнгийн данстай харьцуулан бүртгэсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
7	Төслийн тээврийн хэрэгслээр зарим хугацаанд төсөлд хамааралгүй чиглэл болон хот дотор зорчсон нь холбогдох хууль, шаардлагад нийцээгүй байна.	1	1,606.1	-	-	1	1,606.1	-	-	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>1,874.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>1,606.1</b>	<b>4</b>	<b>268.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хамаарах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, үнэн зөв байршуулсан эсэхийг шалгахад Байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, төсвийн байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэл, санхүүгийн тайлан зэрэг нийт 15 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	-	-	-	1	-
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1215/А015 0079

Улаанбаатар хот

САГ-2026/65/НА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барилга байгууламжийг өмчийн бүртгэлд авах үйл явц удааширсан нь хөрөнгийн эзэн, хариуцагч байгууллага албан ёсоор баталгаажуулаагүй, ашиглалтын болон хамгаалалтын журам бүрэн мөрдөгдөх боломжгүй, санхүүгийн бүртгэлд хөрөнгийг тодорхой хугацаанд тусгаагүй зэрэг алдаа зөрчил гарсан байна. Тухайлбал,

- Дорноговь аймгийн Сайншанд суманд Мал эмнэлгийн лабораторийг 2022 оны 08 сарын 16-ны өдөр;
- Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтын Гаалийн хяналтын лабораторийг 2023 оны 11 сарын 08-ны өдөр;
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд Мал эмнэлгийн лабораторийг 2024 оны 11 сарын 01-ний өдөр;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтын Гаалийн хяналтын лабораторийг 2024 оны 12 сарын 09-ний өдөр тус тус ашиглалтад оруулсан.

Дээрх хөрөнгүүдийг хүлээлгэн өгсөн хугацаанаас хойш Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдан гарсан. Төсөл хэрэгжүүлэгч нэгж барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч өмчийн бүртгэлд авах үйл явц удааширсан нь хөрөнгийн эзэн, хариуцагч байгууллага албан ёсоор баталгаажуулаагүй, ашиглалтын болон хамгаалалтын журам бүрэн мөрдөгдөх боломжгүй, санхүүгийн бүртгэлд хөрөнгийг тодорхой хугацаанд тусгаагүй зэрэг алдаа зөрчил гарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ.”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 9 дүгээр бүлгийн 9.3-д “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.” 9.4-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалтаар хангах бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ” гэсэн заалтуудын хэрэгжилтийг тус тус хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.1 нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-48.Docx

1526181877

хөтөлж, баталгаажуулаагүй, 4.2.1.11 хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилга байгууламжийг өмчийн бүртгэлд бүртгүүлэх үйл явц удаашрах үүнтэй холбоотой үүсэж буй ашиглалтын болон хамгаалалтын журам мөрдөгдөхгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн зохицуулагч Н.Чинзориг, төслийн захирал Ж.Дэлгэржаргал нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

О.ИДШИНРИНЖИН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1216/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/65/КА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газарт лабораторийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нийлүүлэх ажлыг “Мед импекс интернэйшнл” ХХК болон “Сүвэн уул ХХК”-иуд 2020 он, 2021 онд гүйцэтгэж гэрээний үүргээ биелүүлсэн боловч дараах асуудлууд үүссэн байна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын газар татан буугдсанаар хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг аймаг, сумын Гаалийн газарт хүлээлцэхдээ анхны нийлүүлэгчээс хүлээн авсан хөрөнгийн жагсаалтын дагуу хүлээлцэж, баталгаажуулаагүй байна.
- Лабораторийн барилга ашиглалтад ороогүй байхад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын хадгалалтын горим бүрэн хангагдаагүй зориулалтын бус газруудад, тодорхой хариуцах эзэнгүй, байнгын хяналтгүй 4-5 жил хадгалагдсан тул зарим хөрөнгийн бүрэн бүтэн байдал эрсдэлд өртөх, шамшигдан алга болох, мэдрэмтгий чанартай урвалж бодисын ашиглах хугацаа дууссан зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Сангийн сайдын 2021 оны Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 9.2.32-т “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг баримтлан эцсийн өмчлөгчид шилжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.11 хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Лабораторийн барилга ашиглалтад ороогүй байхад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг эзэмшигч, ашиглагч байгууллагад бүрэн шилжүүлж өгөөгүй, зориулалтын бус газруудад хариуцсан эзэнгүй хадгалагдаж буй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 11 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дарга П.Дэлгэрнаран, Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн зохицуулагч Н.Чинзориг, төслийн захирал Ж.Дэлгэржаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

О.ИДШИНРИНЖИН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1217/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/65/НА-СТА-ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн үйл ажиллагаанд ашиглах зорилготой тээврийн хэрэгслийн жолоочийн замын хуудас 2025 оны 10 сар дуустал нийт 13,811 км зам ашигласан ба сүүлийн 11 болон 12 саруудад тээврийн хэрэгслийг ашигласан эсэх нь тодорхойгүй байна. Нийт замын зарцуулалтаас 11,982 км нь орон нутагт явснаас үүний 1,531 км нь Говьсүмбэр, Өмнөговь гэх зэрэг төсөлд хамааралгүй аймгууд руу явсан, үлдсэн 1,829 км нь хот дотор ашигласан байна.


Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", "Сангийн сайдын 2021 оны Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 7.3 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах, төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих үүрэгтэй" гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.4-д төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн санхүүгийн тайланд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг хот дотор ашиглаж байгаа, төсөлд хамааралгүй үйл ажиллагаанд ашигладаг, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 11 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн зохицуулагч Н.Чинзориг, захирал Ж.Дэлгэржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

О.ИДШИНРИНЖИН